



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/660

Мөрөн сум

Цалин шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.8, Засгийн газрын 2022 оны “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох” 491 дүгээр тогтоол, Засгийн газрын 2023 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240 дүгээр тогтоол, Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоол, Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:


1.Сум дундын Ойн ангийн дарга нарын цалинг хавсралтад дурдсанаар шинэчлэн тогтоосугай.

2.Сум дундын Ойн ангийн дарга нарын цалинг хавсралтад заасны дагуу хууль, тогтоомжийн хүрээнд олгохыг сум дундын Ойн ангийн нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

3.Авлига, ашиг сонирхлын зөрчил болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж, ажлын үр дүн гаргаж ажиллахыг сум дундын Ойн ангийн дарга нарт үүрэг болгосугай.


4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Байгаль орчны газрын дарга (П.Мөнхжаргал), Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

Аймгийн Засаг даргын 2024 оны 12
дугаар сарын 04-ний өдрийн А/60 дугаар
захирамжийн хавсралт



ОЙН АНГИЙН ДАРГА НАРЫН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИН,
НЭМЭГДЭЛ, УРАМШУУЛАЛ

№	Албан тушаал	Овог, нэр	Үндсэн цалин	Төрийн алба хаасан хугацаа	Ур чадварын нэмэгдэл /сар бүр/	Орон нутгийн нэмэгдэл	
1	Баяншишгэд сум дундын Ойн ангийн дарга	Б.Нямхишиг	ТҮ-11	14	40	Засгийн газрын тогтоолоор	40
2	Нарс шинэсэн төгөл сум дундын Ойн ангийн дарга	М.Март	ТҮ-11	14	40	Засгийн газрын тогтоолоор	40
3	Дэлгэр мөрөн сум дундын ойн ангийн дарга	Ц.Лхачинбат	ТҮ-11	12	40	Засгийн газрын тогтоолоор	20

_____ оОо _____